

Living the Lotus

Buddhism in Everyday Life

New Year's Issue



2024 оны айлдвар

Агуу зүйлийн төлөө явах

Рисшо Косей Кай,
ерөнхийлөгч Нивано Ничикоо



Яг одоо энэ газар бол зам мөрийн газар гэж хүлээж авах

Эрүүл саруул, эрч хүчтэй сургаал номоо хэрэгжүүлцгээе

Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлье. Шинэ төрлийн корона вирусийн халдвар хамгааллын дэглэм 5-р түвшин болж буурснаар хүмүүсийн аюулаас болгоомжлох мэдрэмж буурч эхэлсэн. Маск зүүх хүн багассанаас үүнийг харж болно. Нөгөөтэйгүүр ийм цаг үеийн өөрчлөлтөнд дасан зохицож чадахгүй, санаа зовох хүн байгаа гэж дуулдана. Тиймээс ялангуяа өндөр настан, архаг өвчтэй хүмүүс, вакцин хийлгэх боломжгүй хүмүүс байгаа гэдгийг маргалгүй үргэлжлүүлэн тэдгээр хүмүүст санаа тавьцгаая.

Япон улсад корона вирусийн халдварын тохиолдол 2020 оны 1 сард анх бүртгэгдсэн. 2019 оны 11 сард гишүүдэд танилцуулсан “2020 оны сүсэг бишрэлийн чиг шугам” дотор миний бие “Байгууллагын 100 жилийн ойг зорин хүн бүр «Энэ газар бол зам мөрийн газар болой» (өөрийн байгаа газраа ариун сүм, номын өргөө хэмээн бодох) гэсэн үзэл санааг эрхэмлэн, сургаалын буяныг хариулцгаая” хэмээн дурдсан.

Корона цар тахлын хөл хорионы үеэр бид бүхэн энэхүү «Энэ газар бол зам мөрийн газар болой» гэсэн үзэл санаа ямар чухал болохыг өөрийн биеэр мэдэрсэн.

«Энэ газар бол зам мөрийн газар болой» хэмээх нь цэнхэр судрын хамгийн эхэнд байдаг

“Бясалгал үйлдэн гэгээрэх замууд” хэсгийн нэг мөрт гэдгийг та бүхэн надаар хэлүүлэлтгүй сайн мэднэ. Энэ мөрт Ариун ордон эсвэл номын өргөө л ганцхан зам мөрийн газар биш. Гэр орон, ажлын байр, сургууль, нутаг ус, нийгэм гэх мэт бидний байгаа газар, амьдарч байгаа газар, түр байрлах газрууд бүгд зүрх сэтгэлээ зүлгэн өнгөлөх зам мөрийн газар мөн гэсэн утгыг илэрхийлнэ.

Корона цар тахлын үеэр зогсохгүй ямарч үед одоо, байгаа газар маань зам мөрийн газар бөгөөд сургаал номыг суралцан хэрэгжүүлэх газар гэдгийг ямагт сэтгэлдээ тээж амьдрах нь бидний хувьд бурханы зам мөрөөр явах замнал битээ. Мөн цар тахлын улмаас олон хүн бие бялдар, эдийн засаг, сэтгэл санааны хохирол амссан. Эргэн босч ирж чадахгүй, ирээдүйдээ итгэл алдрах хүн ч цөөнгүй байгаа бололтой.

“Нэг өдөр бол бүтэн амьдралын товч зураглал” гэсэн үг байдаг. Тухайн хүний амьдрал ямар байх вэ гэдэг өнөөдөр, нэг өдрийг хэрхэн өнгөрөөж байгаагаас харагддаг гэсэн үг юм. Бидний амьдарч байгаа цаг мөч өнгөрсөн биш, ирээдүй биш, одоо яг энэ цаг мөч юм. Номын андууд харилцан бие биедээ тусалж, үргэлж эрүүл саруул, эрч хүчтэй сургаал номоо хэрэгжүүлцгээе.

Ингээд “2024 оны чиг шугам”-ыг би ийнхүү тодорхойлоо. “Хүн төрөлхтөн одоо байгаа байдалдаа сэтгэл ханалгүй, хэмжээлшгүй дээд үнэ цэнтэй, агуу зүйлийг хүсэмжлэх аваас тэнд хүндлэл гэсэн сэтгэл төрдөг. Энэ хүндлэлийн сэтгэл гүнзгийрээд ирэхээр дараагийн ээлжинд хүн өөрийнхөө сул дорой байдлаа олж хараад, түүнээсээ ичих сэтгэл заавал төрдөг. Тэгэхээр хүн хөгжин дэвшихэд хамгийн чухал зүйл бол хүндлэх сэтгэлээ хөгжүүлэх явдал бөгөөд ичиж зовохыг мэддэг байх явдал юм.”

Мэргэдийн хэлсэн дээрх онч үгэнд өгүүлсэн хүний хөгжилд зайлшгүй хэрэгтэй сэтгэлийг тунгаан бодож, энэ жил ч гэсэн сүсэг бишрэл бүхий амьдралаар дамжуулан эхнэр нөхөр, ээж аав, эцэг эхийн хувиар ирээдүйг бүтээх хүүхэд залуусын хүмүүжил, төлөвшилд анхаарч, өрх гэрээ товхиуулж, цаашлаад улс орныхоо өв соёл, уламжлалыг залгамжлан, эв нэгдэл бүхий энх тайван улсыг бий болгохын төлөө тунгаан бодож, бүтээлч санаачлагатай, чин сэтгэлээсээ хандахыг хүсэж байна.”

Хүний хөгжилд хамгийн чухал чанар бол хүндлэх сэтгэлийг хөгжүүлж, ичиж зовохыг мэддэг байх

Дээрх чиг шугамд дурдагдаж буй “мэргэд” гэдэг нь өрнийн гүн ухаан, улс төрийн гүн ухаан судлалын салбарт манлайлагч гэдгээрээ танигдсан Ясүока Масахиро юм.

Хүн төрөлхтөн хэдэн сая жилийн туршид сэтгэлээ хөгжүүлж, улмаар оюун ухаан, ойлгох чадварыг эзэмшиж, түүнийгээ үг, үсгээр илэрхийлж сурсан. Ийнхүү хөгжсөн хүн төрөлхтөн нь амьтнаас олон зүйлээрээ ялгаатай боловч хамгийн гол ялгаа нь хүн төрөлхтөн “хүндлэх” ба “ичиж зовох” сэтгэлийг эзэмшсэн явдал гэгддэг.

Хүндлэх сэтгэл гэдэг нь одоо байгаа байдалдаа баригдалгүй, хэмжээлшгүй дээд, үнэ цэнтэй, агуу зүйлийг хүсэмжлэн, түүндээ ойртохыг хичээх үед төрдөг сэтгэл юм.

Жишээ нь РКК байгууллагын гишүүний хувьд Бурхан багшийг хүндлэн дээдэлж, толгой бөхийлгөн, алга хавсран залбирдаг.

Түүнчлэн бурханы сургаалын мөн чанарыг ойлгон ухамсарлаж, түүнийг хэрэгжүүлж чаддаг хүн болно хэмээн тангараглан ямагт бурханы үйлд шамддаг.

Зөвхөн өөрийнхөө хүсэл мөрөөдлийг биелүүлэхийн төлөө залбираад зогсохгүй, илүү өндөр түвшинд хүрэхийн төлөө тэмүүлж, сургаал номноос суралцах хэрэгтэй.

Илүү ойрын жишээг дурдвал үргэлж гэгээлэг, эелдэг, халуун дулаан ахмад гишүүдээс үлгэр дуурайл авч, “би ч гэсэн энэ хүн шиг болмоор байна” хэмээн хичээх хүн байдаг шүү дээ.

Бид түүхэн алдартай хүмүүс, мэргэд, салбарын манлайлагч нар, спортын тамирчид, өв соёл түгээгч зэрэг янз бүрийн хүмүүсийг үлгэр жишээгээ болгодог.

Төгс биш өөртөө сэтгэл ханалгүй, бага ч гэсэн өсөн дэвшье гэсэн хүсэл нь хүн бүхэнд байдаг төрөлх араншин гэж хэлж болно. Энэ төрөлх араншин нь хүн төрөлхтөний сэтгэлийг хөгжүүлж ирсэн эх үүсвэр юм.

Ийнхүү хүндлэлийн сэтгэл хөгжөөд ирэхээр хүн аяндаа өөрийнхөө дутагдалтай талыг олж харан ичих сэтгэл төрдөг.

“Ичиж зовох” гэдэг үгийн тайлбарыг толь бичгээс харвал, “өөрийн хийсэн үйлдлийн алдаа дутагдлыг ухамсарлаж, түүнээсээ ичих”-ийг хэлнэ гэсэн байна. Хүн өөрийн дутагдалтай талыг барагтай анзаардаггүй. Гэхдээ хүндэлдэг юм уу онцгой хүнтэй учирснаар өөрийнхөө дутуу дулимаг талыг анзаардаг. Улмаар түүнээсээ ичсэнээр өөрийгөө хурцалж, одоо байгаагаасаа илүү хичээл зүтгэлийг гаргаж эхэлдэг.

Мөн “унших нь сайн анд нөхөр”(ном уншсанаар эртний мэргэдтэй анд нөхөр болдог) гэсэн үг шиг эртний ном судрыг уншиж мэргэдээс суралцан, өөртөө дүгнэлт хийж бас болно.

Тийм учраас хүн төрөлхтөний хөгжин дэвшихэд хамгийн чухал нь хүндлэх сэтгэлийг хөгжүүлэх явдал бөгөөд ичих зовохыг мэдэх явдал юм.

Энэхүү хүндлэх ба ичих гэдэг нь угтаа хамтдаа оршин тогтнодог зүйл. Хүндлэх сэтгэл нь шашин шүтлэгт хамаарах бол ичиж зовох нь ёс суртахуунд хамаарна. Тэгэхээр шашин шүтлэг ба ёс суртахуун гэдэг нь огтхон ч тус тусдаа зүйл биш бөгөөд угтаа нэгдмэл зүйл гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй.

Гэр бүлийн хүрээнд хүүхдээ хүмүүжүүлж, зөв төлөвшилтэй хүн болгохын төлөө хичээж, улс орныхоо өв соёл, уламжлалыг залгамжлан, эв нэгдэл бүхий энх тайван улсыг бий болгохын төлөө

Өнгөрсөн жил дурдсан эхнэр нөхөр, ээж аав, эцэг эхийн хувиар ирээдүйг бүтээх хүүхэд залуусын хүмүүжил, төлөвшилд хэрхэн анхаарах вэ, мөн өрх гэрээ хэрхэн товхинуулах вэ, цаашлаад улс орныхоо өв соёл, уламжлалыг залгамжлан, хэрхвэл эв нэгдэл бүхий энх тайван улсыг бий болгох вэ гэдгийг тунгаан бодож, бүтээлч санаачлагатай, чин сэтгэлээсээ хандахыг хүсэж байна хэмээх үндсэн сэдвийг энэ жилийн чиг шугамд ч хөндсөн.

Хүүхэд залуусын хүмүүжил, төлөвшилд хамгийн чухал зүйл бол нийгмийн хамгийн жижиг нэгж болох гэр бүл дотроо бурхан тахилаа хүндэлж, хүнийг хүмүүжүүлж төлөвшүүлэх “товхиносон өрх гэр”-ийг бүтээх явдал юм.

Өмнө нь миний бие та бүхэнд “Аав нь хүүхдийнхээ хүндлэлийн бай байх нь зохимжтой. Ээж нь хүүхдийнхээ хайр энэрэлийн суудал байх нь зохимжтой. Учир нь гэр бүл бол хүүхдийн нахиалан үрслэх хөрс юм” гэсэн үгийг танилцуулж байсан.

Хүүхэд байгалаасаа аавыгаа хүндэлж, ээжийгээ хайрладаг гэдэг. Улмаар эцэг эхийнхээ үг үйлдлийг харж суралцан, дуурайдаг.

Тиймээс эцэг хүний хувьд хүүхдийнхээ хүндлэлийг хүлээж чадахуйц хүн болох маш чухал. Ажилдаа хамаг анхаарлаа хандуулаад гэр бүлээ тоохгүй байх, эсвэл өөрийн бодлоо тулган үглэж сургах, амралтын өдөр гэртээ юу ч хийхгүй байх зэргээс зайлсхийх хэрэгтэй.

Мөн эх хүн ямарч хүүхэд байсан нөхцөлгүйгээр хүлээн авч, халуун дулаан хайраар өсгөдөг. Цаашлаад хүүхэд насанд хүрч, биеэ даахад хойшдоо гайгүй байгаа даа” хэмээн санаа зовж, шаналахыг эх хүний хайр хэмээн үздэг.

Ийм эцэг эхийн халамжинд хүүхэд эрүүл саруул, эрч хүчтэй хүн болон өсөж торнидог.

Нөгөөтэйгүүр сүүлийн жилүүдэд Орос улсын Украин улс руу хийсэн дайралт, Израиль Палистины зэвсэгт мөргөлдөөн зэрэг зөрчилдөөн ар араасаа болж, олон зуун хүн хохироод байна. Ядуурал, цаг агаарын өөрчлөлт, байгаль орчны бохирдол, ундны ус, хоол хүнсний дутагдал, байгалийн гамшиг зэрэг асуудлууд уул овоо шиг овоорсоор байна.

Эдгээр ээдрээтэй олон асуудал нэг өдөрт шийдэгдэх боломжгүй ч бид бүхэн үргэлж буурь суурьтай хянамгай байж, бууж өгөлгүй алхам алхамаар урагшлах нь зүйтэй.

Өмнө нь дурдаж байсанчлан Япон улс эрт дээр үед улсынхаа нэрийг “Ямато” гэж нэрлээд, “агуу энх тайван” “агуу эв нэгдэл” гэсэн санааг үеийн үед баримтлах улсынхаа зарчим болгож ирсэн.

Хунтайж Шоотоку (593-622) “Улс орны үнэ цэн бол эв нэгдэл юм” гэсэн мөргийг 17 зүйлт үндсэн хуулийнхаа хамгийн эхний зүйлд бичсэн байдаг.

Иймэрхүү үзэл санаа нь Япон улсаар зогсохгүй, хил хязгаар хамааралгүй ямарч улс оронд үйлчлэх энх тайвны үзэл мөн гэж итгэдэг.

Япон улсын өв уламжлалыг залгамжилж, Япон улсыг бат бөх эв найрамдалтай улс болгож, түүгээрээ дэлхийн дахинд нөлөө үзүүлэх явдал нь бидний чухал зорилго билээ.

Үүний зэрэгцээ өдөр дутамдаа ажлын байр, сургууль, нутаг ус, гэр бүл гэх мэт одоо байгаа газартаа бусдад санаа тавьж, бодьсадвагийн үйлийг хэрэгжүүлэх тал дээр анхаарахыг хүсэж байна. Таны зүтгэлийг хэн ч үнэлэхгүй байсан төлөв түвшин байж, үргэлжлүүлэх хэрэгтэй.

“Нэг зулын гэрэл эргэн тойрноо гэрэлтүүлдэг бол түмэн зулын гэрэл хорвоо дэлхийг гэрэлтүүлнэ” гэсэн зүйр цэцэн үг байдаг. Нэг зулын гэрэл эргэн тойрноо гэрэлтүүлнэ гэдэг шиг өөрөө зул болон гэрэлтэх аваас эргэн тойронд тань гэрэлтэй гэгээтэй болно гэсэн үг юм. Түмэн зулын гэрэл гэдэг нь нэг нэг зулын жижиг гэрлүүд нэгдээд түмэн зул болох аваас хорвоо дэлхийг бүхэлд нь гэрэлтүүлэх болно гэсэн утгыг илэрхийлнэ. Иймд эхлээд өөрөө алхам хийх хэрэгтэй гэж бодож байна.

Амьдралд санаанд оромгүй хэцүү саад бэрхшээл тохиолдох үе байдаг. Гэхдээ хүн зовлон бэрхшээл байгаа болохоор л түүнийг давж туулахад шаардлагатай бодь сэтгэлийг хөгжүүлдэг. “Зүрх сэтгэлийг хөгжүүлж, дээшлүүлэх боломж” гэж хүлээн авч, ойрын хүмүүс, урдах ажилдаа чин сэтгэлээсээ хандвал тэр нь “энэ газар бол зам мөрийн газар болой” хэмээх үзэл санааг хэрэгжүүлж байгаа явдал бөгөөд бодь сэтгэлээ хөгжүүлж байгаагийн илрэл билээ.

Хүн бүр илүү агуу, дээд зүйлийг хүсэмжлэн, өөрийнхөө алдаа дутагдлыг боломж болгон урвуулж, алхам алхамаар хөгжихийг чин сэтгэлээсээ хүсэж байна.

